



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/305

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 “а”, 29.1.3 “б”, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих жил” болгон зарлах тухай 03/06 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн “Зорилтот жилийн төлөвлөгөө батлах тухай” А/31 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголын хоолойн тэмээ, Тээлийн улаан ямааны нутгийн шилмэл сүргийг омог болгон батлуулах ажилд 4,100,000 (дөрвөн сая нэг зуун мянга) төгрөг, Баянгол омгийн хонийг үүлдрээр, Уянгын сарлаг үхрийг омгоор баталгаажуулах судалгааны ажлын арга зүйг боловсруулан, батлуулахад 4,100,000 (дөрвөн сая нэг зуун мянга) төгрөг, GPS худалдан авахад 1,200,000 (нэг сая хоёр зуун мянга) төгрөг, зорилтот жилийн ажлын төлөвлөгөөг англи хэл дээр хөрвүүлэх зардалд 250,000 (хоёр зуун тавин мянга) төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Дээрх 9,650,000 (есөн сая зургаан зуун тавин мянга) төгрөгийг орон нутгийн төсөвт батлагдсан зорилтот жилийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100646